



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/375

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.1.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн соёлын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй "Соёлын сэргэлт-2023" аяныг орон нутагт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, аянд зарцуулагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтад заасан 1,633,400 (нэг сая зургаан зуун гучин гурван мянга дөрвөн зуу) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3."Соёлын сэргэлт-2023" аяныг орон нутагт үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг (сумын Засаг дарга) нарт, арга хэмжээг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А. ИШДОРЖ

6223 11 0726

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
сарын 08-ны өдрийн 43 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Ганбат (Арвайхээр сумын Засаг дарга)

Д.Тогтох (аймгийн Музейн захирал)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын Театрын
дарга)

Л.Анхбаяр (аймгийн Төв номын сангийн захирал)

Н.Чимэддорж-Ойдов (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Боловсрол, шинжлэх
ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Цэвээндулам (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

С.Шийлэгцэрэн (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын
Захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Л.Пүрэвлхам (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын Соёл,
урлагийн хэлтсийн дарга)

Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: Д.Өсөх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх
асуудлын хүрээний агентлаг Соёл, урлагийн газрын
дарга)

-oOo-

Аймгийн Засаг даргын 2023 оны ... дугаар
сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



**“СОЁЛЫН СЭРГЭЛТ-2023” ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БЭЛТГЭЛ
АЖЛЫН ЗАРДАЛ**

	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Мөнгөн дүн
1	Шатахуун АИ-92	литр	49,9 (2 машин)	2,470	123,400
2	Цайны зардал	хүн	58	10,000	580,000
3	Техник , апартурын түрээсийн зардал	цаг	4	100,000	400,000
4	Автомашин жолоочын зардал	Хүн	2	90,000	180,000
5	Тайз , техник хэрэгсэл, шовгор угсрах ажилчдын хөлс	Хүн	5	70,000	350,000
Бүгд 1,633,400₮					

-оОо-